

ЗАНАБАЗАРЫН БУТЭЭСЭН БУРХАДУУДЫН ТУХАЙ

Б.Дэлгэрмаа (Ph.D)

Философи, шашин судлалын тэнхим

ШУС, МУИС

Д.Гоомарал

*Занабазарын музейн
эрдэм шинжилгээний ажилтан*

Түлхүүр угс: Анхдугаар Богд, буддын шашины урлаг, бурхан урлал

*Төвч утга: Энэхүү илтгэлдээ Анхдугаар богд Өндөр гэгээний бутээсэн бурхадын
талаар өгүүлнэ.*

* * * * *

Өндөр гэгээн Занабазар нь эзэн Чингис хааны алтан ураг, боржигон овогт хиад ястан Чингис хаанаас угсаа залган суусан 31 дэх их хаан Бат-Мөнх даян хааны отгон хөвгүүн Гэрсэнзийн үр сад ажээ. Түшээт угийн бичигт “Халхын сүсэг хүчин төгссөн номун Очирабат Түшээт хааны уг эх, угсаа залгамжилсан үе удам овог цолыг байцааваас, Батмөнх даян хааны (1464-1517 он) отгон хөвгүүн Гэрсэн Жалайр хунтайж (1513-1549 он), түүний гуравдугаар хөвгүүн Онохуй үйзэн ноён түүний ахмад хөвгүүн Автай сайн хаан (1554-1588 он) түүний хоёрдугаар хөвгүүн Эрхий Мэргэн (1578-1610-аад он), түүний ахмад хөвгүүн Түшээт Гомбодоржийн (1594-1655 он) эхийг¹ тодорхойлжээ.

Г.Занабазар Монголын анхны богд (гэгээн), Чингис хааны алтан ургийн удам Гомбодоржийн Занабазар (1635-1724 он) тухайн үеийн шашны дүрслэлийн урлагт шинэчлэл хийсэн билээ. Тэрээр уран барималч, зураач, яруу найрагч, одоогийн нийслэл Улаанбаатар хотын туурь Их хүрээг байгуулж, сүм хийдийн уран барилга, “Соёмбо” үсгийг бутээсэн зуу зуунд алдаршсан соён гэгээрүүлэгч юм. Г.Занабазарын “Язгуурын таван бурхад”-ын дөрөв, “Цагаан дарь эх”, “Бодь суварга” алтан шармал, хүрэл цутгуур баримлууд болон “Эх Ханджамцын”, “Өөрийн” хөрөг зургууд нь музейн эрдэнэсийн дээжис төдийгүй дэлхийд алдаршсан хосгүй бүтээлүүд юм.

Дэлхийн урлагийн эрдэнэсийн санд монгол хүний оруулсан бодит хувь нэмэр бол Г.Занабазарын бүтээлүүд мөн. Занабазар нь (1635-1723 он) уран баримлын урлагт цутгамлын давтагдашгүй аргыг үндэслэсэн бөгөөд энэ арга нь одоо ч судлаачдын анхаарлыг татсаар байгаа билээ. Өндөр гэгээн бурхадыг дүрслэхдээ биеийн болон сэтгэлийн гоо сайхныг амьд хүмүүн мэт сэтгэл төрүүлтэл харуулж чадсан байдал. Энэхүү хэв маяг нь өдгөө “Занабазарын хийц” хэмээн нэрлэгдэх болсон. Занабазар шашны урлахуйн ухаанд хүнлэг шинжийг илүүтэй шингээж, хүрэл цутгуурын аргаар урлах бүрэн боломжийг нээсэн нь уран баримлын тусгайлсан дэг жаяг болж чадсан билээ.

Монголын анхдугаар Богд Өндөр гэгээн Занабазар нь Цагаан дарь эх, Ногоон дарь эх, язгуурын таван бурхан зэрэг олон бурхадуудын баримлыг бутээсэн юм. Музейд хадгалагдаж буй Занабазарын бүтээлийн цуглуулгаас бид энэхүү илтгэлдээ “Зөвлөн эгшигт”, “Язгуурын таван бурхан”, “Бодь суврага”, “Аюуш”, “Цагаан дарь эх”, “Ногоон дарь эх” бүтээлүүдийг онцлон бичлээ. Занабазарын бүтээлийн оргил нь **Цагаан дарь эхийн баримал** юм.

¹ С.Ичинноров. Өндөр гэгээн Занабазар намтар, түүхийн зарим асуудал. УБ., 2005 он, 11 дэх талд

Өндөр гэгээн Занабазарын урлалын хамгийн алдартайд тооцогдох бүтээл бол “Цагаан дара эх” билээ. (Цагаан дара эх: Мон: Цагаан гэтэлгэгч эх, Цагаан дара эх, Төвд: Долгар, Санс: Сита Тара Хэмжээ: 69x45x45 см, 53830 гр).

Тэргүүндээ гурав, мутрын алга, хөлийн улнаа тус бүр мэлмийтэй тул “Долоон мэлмийт Цагаан дара эх” хэмээн алдаршсан. Эдгээр мэлмий нь өнгөрсөн, одоо, ирээдүй турван цагт олонд өглөг буянаа өгч, энэрэн хайлаж байна гэсэн бэлгэдэлтэй.

Дарь эхийн лагшигийн өнгө болор мэт тунгалаг, намрын сар мэт цагаан, 16 настай төгөлдөр ариун охины мишээсэн амгалан дүртэй, цагаан лянхуа дээр саран түшлэг налан заларч, үнэт эрдэнэсийн чимэг зүүсгэлтэй, торгон хормойвчтой, зүүн мутартаа цагаан лянхуа цэцэг барьж, баруундаа хамаг амьтныг насны зэтгэрээс гэтэлгэж, нас уртасган, өвчин зовлонгоос ангижруулах өглөгийн мутарлага зохиосноор дүрслэгдсэн юм.

Г.Занабазар бүтээлээ үндэсний сэтгэлгээгээр баяжуулан, монголжуу зөвлөн, төв ихэмсэг дүр төрхийг харуулахдаа, арвайн адил урт зууван мэлмий, угалзтай шулуун хамар, ул мэдэг инээмсэглэсэн уруултай, нүүр биеийн хэлбэр гар хуруу булбарай, орь залуу, үзэсгэлэн төгөлдөр шинж нь бүрдэж яваа эгэл эмэгтэйн дүртэй гаргасан байна. Зүүн мөрөн дээрх дөнгөж нүдлэн цоморлигоо нээж байгаа цэцэгтэй адилтган монгол бусгүй хүний гоо сайхны сонгодог дүр төрх болгон бүтээсэн байна.

Г.Занабазар **Ногоон дарь эх** хэмээх амгалан дүрт бурханаа бүтээхдээ, эгэл монгол эмэгтэйн дүрээр бүтээсэн байдаг. Ногоон дарь эх нь баруун хөлөө лянхуат суудлаас сунгаж, зүүн хөлөө хумин, саран дэлгэрсэн лянх дэвсгэр дээр ногоон модны салаа сунгах адил баруун мутарт дээдийг өгөх хөлөл зохиож урагш сунган өвдөг орчимдоо аваачиж, зүүн мутартаа гурван эрдэнэ цогцлоон, аврал өгөх мутарлага үйлдэнэ. Гэгээн царай нь тэргэл саран мэт мишээсэн, амирлангуй дүрт, уужим мэлмийт, маргад уул солонго өмссөн мэт биеийн дээд хэсэгт тортон цээживчтэй. Хоёр мутраар барьсан хөх удвал цэцэг амьтан бүхэнд номын хурыг оруулж, бие, хэл, сэтгэлийн амар амгаланг айлддаг.

Г.Занабазар бүтээсэн Язгуурын таван бурханы дөрөв нь Занабазарын музейд хадгалагдаж байна. Язгуурын таван бурхан хүнд байдаг нисваанисийн таван хор болох уур хилэн, шунал тачаал, мунхаг харанхуй, атаа жетөө, харам сэтгэлийг тэвчин ялахын бэлгэдлийг илэрхийлдэг. Эдгээр бурхад нэг хэвэнд цутгасан мэт хоорондоо адил төстэй харагдавч мутрын хөдөлгөөн, өмсгөл, чимэг зүүсгэл цөм давтагдашгүй өөр өөр байдаг.

1. (**Машид гийгүүлэн зохиогч:** Мон: Машид гийгүүлэн зохиогч, Төвд: Намнан-Намбарнанзад, Санс: Вайрочана. Материал: Хүрэл, алтан шармал, шороон будаг Хийц, арга техник: Цутгамал)

Язгуурын таван бурханы нэг Машид гийгүүлэн зохиогч бурхан нь дэлбээгээ нээж буй бадамлянхуа цэцгийн дүрст дугуй суурин дээр очир завилгаа суудлаар заларч, хоёр мутраа тохойгоор нугалан, бодь сэтгэлийг үүсгэн, хүсэл соёрхогч мутарлага үзүүлэн цээжин тушаа аваачин, мунхаг харанхуйг дараахыг бэлгэдэн дорно зүтг оршино. Уг баримлыг хүрлээр нэгэн бүхэл атлаа хөндий цутгаж, алтаар шарсан ба хэвнээсээ их биетэйгээ хамт цутгадсан, титэм, ээмэг, зүүлт, бугуйвч, шагайвч болон суурины иж бүрэн чимэглэлийг хөөмөл, цоолтворын аргаар тодруулж ялангуяа нимгэн тортгомсог, хувцас, туузан нөмрөг, түүний материаллаг чанарыг маш нарийн урлаг төгс бүтээжээ.

2. (**Цаглашгүй гэрэлт**: Мон: Цаглашгүй гэрэлт, Авид, Төвд: Одбагмэд (od.dpag.med), Санс: Amitabha. Хэмжээ: 70.5x45.5x45.5 см, 52250 гр Материал: Хүрэл, алтан шармал, шороон будаг)

Язгуурын таван бурханы нэг Цаглашгүй гэрэлт бурхан нь дэлбээгээ нээж буй бадамлянхуа цэцгийн дүрст дугуй суурин дээр очир завилгаа суудлаар заларч, зүүн мутрын алган дээр баруунаа тавин, шийдвэр төгөлдөр бясалгалын мутарлага үзүүлэн, шунал тачаангуйг даран өрнө зүгт оршино. 1995 онд Америкийн Нэгдсэн Улсын Сан-Франциско хотод болсон үзэсгэлэнд оролцжээ.

Уг баримлыг хүрлээр нэгэн бүхэл атлаа хөндий цутгаж, алтаар шарсан ба хэвнээсээ их биетэйгээ хамт цутгагдсан, титэм, ээмэг, зүүлт, бугуйвч, шагайвч болон суурины иж бүрэн чимэглэлийг хөөмөл, цоолтвороын аргаар тодруулж ялангуяа нимгэн торгомсог, хувцас, туузан нөмрөг, түүний материаллаг чанарыг маш нарийн урлаг төгс бүтээсэн байна.

3. (**Үйл бүтээгч**, Төвд: Дондүв, Санс: Amoghasiddhi. Хэмжээ: 70x45.5x45.5, 57400 гр Материал: Хүрэл, алтан шармал, шороон будаг).

Язгуурын таван бурханы нэг Үйл бүтээгч бурхан нь дэлбээгээ нээж буй бадамлянхуа цэцгийн дүрст дугуй суурин дээр очир завилгаа суудлаар заларч, зүүн мутрын алгыг дээш харуулан баруун хөлийн өсгийд хүргэн тосч, баруун мутраа тохойгоор нугалан, цээжин тушаа аваачин аймшиггүйг соёrhoх мэт үйл бүтээх мутрын тэмдэг үзүүлэн, атаа жөтөөг арилгаж умар зүгт оршино.

4. (**Үл хөдлөгч**: Мон: Үл хөдлөгч, Хөдлөш үгүй, Төвд: Мижодва , Санс: Акчоба. Хэмжээ: 71x46x46, 60250 гр. Материал: Хүрэл, алтан шармал, шороон будаг)

Язгуурын таван бурханы нэг **Үл хөдлөгч** бурхан нь дэлбээгээ нээж буй бадамлянхуа цэцгийн суурин дээр очир завилгаа суудлаар заларч, баруун мутраа сунган өвдөг дээрээ тавин алгыг доош харуулан дунд хурууны үзүүрээр газарт хүрэн, зүүн мутрын алгыг дээш харуулан өглөгийн зангаа буюу дээдийн зэрэгт бодь сэтгэлийн илтгэж, ялалт бэлгэдсэн мутрын тэмдэгтэй, уур хилэнг дарагч хот мандлын төвд орших бурхан юм. Энэ бүтээл 1995 онд Франц улсад үзэсгэлэнд оролцож байсан.

(**Зөөлөн эгшигт**: Мон: Зөөлөн эгшигт, Төвд: Жамбал, Санс: Манжушири, Хэмжээ: 58x20x20 см, 13250 гр Материал Хүрэл, алтан шармал, шороон будаг).

Зөөлөн эгшигт нь Язгуурын гурван бурхны нэг Манжуширийг Монголчууд Зөөлөн эгшигт хэмээн нэрлэж заншсан ба улбар шар дүртэй, амирлангуй зөөлөн намбатай, нэг нүүр, хоёр мутартайгаар дүрслэгддэг. Зөөлөн эгшигт бурханы баруун мөрөн дээр цогцлох цэцгийн дээр мунхаг харанхуйг тасчин гийгүүлэх утга бүхий илд, зүүн мөрөнд цогцлох бадамлянхуа цэцгэн дээр оюун билгийн судар залсан байна.¹

Хүрлээр нэгэн бүхэл атлаа хөндий цутгаж, алтаар шарсан ба хэвээсээ эх биетэйгээ хамт цутгагдсан, титэм, ээмэг, зүүлт, бугуйвч, шагайвч болон суурины иж бүрэн чимэглэлийг хөөмөл, цоолтвороын аргаар тодруулан урлажээ.

Язгуурын таван бурхад

¹ Н.Саруул, Д.Гоомарал. Хосгүй үнэт бүтээлүүд. (Ред: У.Сарантуяа). УБ., 2018 он, 10 дахь талд

Өндөр гэгээн Занабазар нь 1680-аад онд уран бүтээлийнхээ оргилд хүрч, Язгуурын таван бурханыг бүтээжээ. Эдүгээ Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд хадгалагдаж байна. Язгуурын таван бурхны тав дахь нь Раднасамбава бурхан нь Чойжин ламын сүм музейд хадгалагдаж байна. Таван бурхан нь хэмжээний хувьд ижил чимэг зүүлт, титэм, дүр төрхөөрөө тус бүр ялгаатай. Бурхан бүрийн дүр төрхийг хээ угалз, зүүлт чимэглэл зэргээр ялгаруулан тодруулжээ¹.

5. (**Бодь суврага:** Мон: Суварга, Төвд: Ступа, Санс: Ступха. Хэмжээ: 70x46x45 см, 36300 гр, Материал: Хүрэл, алтан шармал, шороон будаг).

Занабазарын намтарц дурдагдсан нэгэн бүтээл бол Бодь суврага юм. Занабазар гарцаагүй бүтээсэн гэгдэх бодь суврага бол Эртний Энэтхэг Ашока хааны ивээлээр олон арваараа бүтээгдсэн, дороосоо дээш тэгш хэмээр нарийсгаж, орой дээрээ арслан, заан, буга зэрэг амьтдын дүрсээр чимэглэсэн сүрлэг суврага болон Дорно дахины орнуудад үлэмж дэлгэрсэн бодоо дөрвөлжиндүү сутпа хэлбэрийн сурваганаас ялгаатай юм. Сувраганы зохиомж нь сэнти буюу арслант суудал, хэмжээлшгүй дөрвөн үнэнийг билэгдсэн дөрвөн шат, бурхан багшийн бэсрэг хөрөг баримал бүхий бумба хэлбэрийн агуй, Чойнхоржүсүм буюу номын 13 хүрд зэрэг үндсэн дөрвөн хэсгээс бүрдсэн бөгөөд тэдгээрийн уран сайхан яруу зохицол, уран барилгын шүтэлцээ нэгдэл нь Занабазарын уран барилгын гайхамшигт арга ухааныг гэрчлэн харуулдаг. Сувраганы сэнти буюу суурийг Монголчуудын нэн эртнээс эрхэмлэн хүндэтгэж ирсэн морин эрдэнэ, заан эрдэнэ, хүч чадлыг билэгдсэн хос арслангаар чимэглэсэн хийгээд сувраганы орой дээр мөнх хөх тэнгэрийн чимэг болон цогцлон байгаа нар сарыг хараход арга билэг, эр, эм үүтгэлийн тухай олон зүйлийг эргэцүүлэн бодоход хүргэдэг. Бодь сувраг нь ийнхүү домог зүйн монгол сэтгэлгээ, зөн билэгдлийн хэллэгээр цогцлон² байх бөгөөд маш тансан нарийн хээ чимэглэлтэй.

Аюуш: Бидний өгүүлэлд Занабазарын нэгэн бүтээлийг онцлон дурдаж байгаа нь 2015 онд Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейн сан хөмрөгт бүртгэгдэн хадгалагдаж буй “Аюуш” хэмээх бүтээл юм. (Тус бүтээл нь Өндөр: 19.5 см, Жин: 2040 гр, Диаметр: 12.3 см-тэй хүрэл цутгуур, алт шармал, шороон будаг). Аюуш нь Хоёр мутартаа бумба барьж, дугуй бад суурин дээр заларсан. Жүгдэргүй хөх өнгө өргөсөн байна. Суурины тагны ёроолд товгор нацагдоржтой. Тус бүтээлийг Унгар улсын иргэн Ласло Кадар. БСШУЯ. Бэлэг, шилжүүлгээр БСШУЯ-ны Сайдын 2015.04.24 A/244 тоот тушаал³-аар Монгол улсад бүртгэн авсан.

Өндөр гэгээн бурхадаа үл анзарагдам чимхлүүр хэсэг, зүүлт, хээ угалз зэргээр чимж бүтээдэг. Өндөр гэгээний олон бүтээлээс Язгуурын таван бурхыг ард түмэн ороо бусгаа цагийн аюулаас хамгаалан авран үлджээ. Орчин үед ч ард түмэн түүний бүтээлийг өөрийн үндэсний бэлгэ тэмдэг, эв нэгдэл, аюулгүй байдлын гол бэлгэдэл хэмээн биширсээр байна.⁴ Занабазарын бүтээлүүд өмнөх үеийн урлаг суурилан бүтээгдсэн ба үндэстний уламжлал гэдэг ухагдахуун нь ганц өнгөрсөн урлагийн өвд бус түүний өнөөгийн туршилагад нэгэн адил холбогдоно. Эртний Монголын урлагт хүний өөрийн зөн билэг болон аливаа зүйлийг адил төстэй дүрслэхдээ гоо сайхны мэдрэмжээр хүлээн авч

¹ У.Уранчимэг. Монголын их хүрээ хийдийн буддын шашны урлаг. УБ., 2016 он, 60 дахь талд

² Өндөр Гэгээн Занабазар. УБ., 1995 он, 76 дахь талд

³ Дүрслэх урлагийн музейн бүртгэл

⁴ У.Уранчимэг. Монголын их хүрээ хийдийн буддын шашны урлаг. УБ., 2016 он, 73 дахь талд

илэрхийлдэг байсан хийгээд байгаль дээр байдаг юмс, үзэгдэл, үлгэр домогт гардаг ан амьтдын дүрс зонхилсон хээ угалз их тааралддаг. Хээ угалзан урлаг бол чимэглэх буюу хэрэглээний өндөр шаардлагаас болж эрхэм дээд буюу энгийн урлалын хэрэгцээнд олон хэлбэр зүйлийн ухагдахуунаар уламжлагдан өргөн хэрэглэгдэж ирсэн байдаг. Монголын урлагийн түүхэнд XVII-XIX зуунд буддын шашны урлаг хүчтэй дэлгэрсэн нь дорно дахинь орнуудтай соёлын харилцаа, харилцан нөлөөлөл их байсантай холбоотойн дээр Монгол буддын шашны нөлөө асар их байсныг хамгийн ихээр харуулжээ.

НОМ ЗҮЙ

1. С.Ичинноров. Өндөр гэгээн Занабазар намтар, түүхийн зарим асуудал. УБ., 2005 он
2. Б.Дэлгэрмаа. Гоо зүй. УБ., 2011 он
3. Өндөр Гэгээн Занабазар. УБ., 1995 он
4. Н.Саруул, Д.Гоомарал. Хосгүй үнэт бүтээлүүд. (Ред: У.Сарантуяа). УБ., 2018 он
5. Ж.Төмөрбаатар. Монголын гоо сайхны сэтгэлгээний түүхэн тойм. УБ., 2010 он
6. У.Уранчимэг. Монголын их хүрээ хийдийн буддын шашны урлаг. УБ., 2016 он

ABSTRACT

G. Zanabazar (the first Bogdo of Khalkha, a reincarnation of Jebtsundamba, and often referred to as Öndör Gegeen).

He is one of the most fascinating persons of Mongolian art history and Mongolian history in general. Öndör Gegen Zanabazar could study in Tibet thanks to the close political and religious connections between Tibet and Mongolia in the 17th century. This period was the time of the 5th Dalai Lama, the head of the Gelug sect (Yellow-hat sect), who lead the country as a theocratic ruler. Buddhism flourished in Tibet and lots of Mongolian monks studied in Lhasa. Among them one of the most significant persons was Zanabazar. Returning to Mongolia he started a unique career. As a reincarnation of Taranatha he received the name of Wisdom Vajra that is Jñāna-Vajra in Sanskrit and this name twisted to Zanabazar in everyday use. He studied in the monasteries of Kumbum, Tashilhunpo and Lhasa. He worked as a sculpture and architect, but he was a political and religious leader too.

As a sculptor his speciality was the so-called lost-wax casting. In terms of quality his sculptures are masterpieces. The whole body is cast as one piece, the separately made underside is richly decorated, and the joining of these pieces is invisible. His pieces radiate harmony and softness. He contributed to the development of more art branches, but his work within sculpture is prominent. Zanabazar discovered a casting method which allowed him to create statues without the need for welding.

Zanabazar produced a series of sculptures classified today as belonging to the style of the ‘Zanabazar school’, characterized as hollow yet seamless brass castings expressing the ideals of philosophy, beauty and mercy. The museum displays his famous works such as the ‘Five Dhyani Buddhas’, ‘White Tara’, and ‘Bodhi Stupa’ which glorify wisdom, beauty and Bodhisattva.

In Mongolian art in general the nomadic tradition, its material and non-material culture is strongly felt. We can see it in Zanabazar’s works as well. One of the sculptures from the Zanabazar school can find in the Museum is the Green Tara. This piece not only fulfills religious

requirements, but it shows female beauty to its full extent. The figure is closer to an everyday beauty than to a divine one. He combined religious and traditional folk art in his works. Mongolians not only learnt a foreign language and culture but they shaped it according to their own needs and taste, keeping the elements of folk art too.

In Ulan Bator, we can find his statues in the collections of the Bogd Khaan Palace Museum, the Chojin Lama Museum, and the Fine Arts Zanabazar museum.